

## МОНГОЛБАНКНЫ ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛӨӨС ШИЙДВЭР ГАРГАВ

Монголбанкны Хяналтын зөвлөлийн ээлжит хурал 2011 оны 3 дугаар сарын 25-ны өдөр болж, энэ оны ажлын төлөвлөгөөнд тусгагдсан асуудлууд, тухайлбал Монголбанкны хүний нөөцийн удирдлагын асуудал, Монголбанкаас нэр бүхий алт олборлогч 4 компанитай үүссэн авлагыг барагдуулах ажлын явц, үр дүнг болон Хяналтын зөвлөлөөс 2010 онд гаргасан шийдвэрийн хэрэгжилтийн байдал зэрэг асуудлыг авч хэлэлцсэн байна.

Монголбанк нь Хяналтын зөвлөлийн зөвлөмжийн дагуу „Хүний нөөцийн бодлого“ баримт бичиг боловсруулан баталж, мөрдөн боловсон хүчнийг сонгох, ажилд авах, дадлагажуулах, ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зэрэг хүний нөөцийн бодлогын асуудалд иж бүрэн хандах болж, ажлын нааштай өөрчлөлт гарч байгааг Хяналтын зөвлөл тэмдэглэж, Монголбанкны удирдлагад дараах зөвлөмж хүргүүлсэн байна. Үүнд:

- Ажлын давхардлыг арилгах, илүү шат дамжлагыг цөөлөх, ажилтны мэргэшлийн ур чадварыг дээшлүүлэх, ажилтны карьер өсөлт хөгжлийн үзүүлэлтийг үнэлэх стандарт тогтоон мөрдүүлэх, хүнд суртлыг багасгах, хээл хахуульд өртөхөөс сэргийлэх зэргээр олон улсын шаардлагад нийцүүлэн Монголбанкны бүтэц, зохион байгуулалтыг улам боловсронгуй болгож ажиллах;

- Монголбанкны хүний нөөцийн бодлогын баримт бичиг, хүний нөөцийн дунд хугацааны төлөвлөгөөг ажилтнуудад сурталчилж ойлгуулах улмаар хүний нөөцийн удирдлагын тогтолцоог цахим мэдээллийн нэгдсэн сүлжээний төвшинд хүргэх,

- Нийт ажилтны дотор банкны мэргэжлийн хүмүүсийн эзлэх хувийг нэмэгдүүлэх, мэргэшүүлэх, мэргэшсэн ажилтны зэрэг дэв бий болгох, түүнд үзүүлэх урамшлын тогтолцоог бий болгох,

- Хүний нөөцийн бодлогын талаар гадаадын болон дотоодын зарим байгууллагын туршлагыг судалж, хүний нөөцийн албыг чадваржуулах, бэхжүүлэх ажлыг Монголбанкны жилийн төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэх.

Хяналтын зөвлөлийн хурлаар Алт олборлогч “Монгол газар”, “Эрдэс”, “Монполимет”, “Хайлааст” ХХК-тай холбогдож үүссэн өр авлагыг барагдуулах талаар Монголбанкинд УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооноос өгсөн даалгавар болон Хяналтын зөвлөлөөс удаа дараа өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажилд тодорхой ахиц өөрчлөлт гарч үр дүнд хүрээгүй байна гэж үзэв.

Хяналтын зөвлөлөөс өнгөрсөн онд Монголбанкинд хүргүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийн явцыг хэлэлцэж, энэ талаар Монголбанкны удирдлагын зүгээс зориуд анхаарч, ажлын нааштай ахиц өөрчлөлт гарч байгааг Хяналтын зөвлөл тэмдэглэсэн байна. Хяналтын зөвлөлөөс 2010 онд нийт 29 заалт бүхий шийдвэр гаргаснаас 11 заалт нь бүрэн хэрэгжиж, 5 заалт нь хэрэгжих явц дундаа байгаа бөгөөд харин 8 заалт нь дутуу биелэлттэй, 2 заалт хэрэгжээгүй байгааг Хяналтын зөвлөлийн хурлаас тэмдэглэж, цаашид Хяналтын зөвлөлөөс Монголбанкинд хүргүүлж байгаа шийдвэрийг хэрэгжүүлэх талаар

холбогдох газар, хэлтэс, албаны захирлын хариуцлагыг дээшлүүлэх арга хэмжээ авахыг Монголбанкны удирдлагад зөвлөхөөр шийдвэрлэсэн байна.

Мөн Хяналтын зөвлөлийн хуралд оруулах асуудлын боловсруулах чанарын төвшинг дээшлүүлэх, Хяналтын зөвлөлөөс гарах шийдвэрийг оновчтой, тодорхой байдлаар боловсруулж, хуралд оруулж байхыг Хяналтын зөвлөлийн гишүүдэд үүрэг болгосон байна.

## МОНГОЛБАНКНЫ ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛ